



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3 - 6

1. *Байнгын хорооны тогтоолын төсөл /“Газрын тухай болон Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, газрын зөвшөөрөл олголт, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төсөвт төлөх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж санал, дүгнэлт гаргах, хянан шалгах түр хороо байгуулах бэлтгэл хангах” үүрэг бүхий Ажлын хэсгийн удирдамж батлах тухай/*

3 - 6

**Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны
2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 00 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

*Томилолттой: Д.Батлут, Ж.Ганбаатар, Н.Ганибал, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Ч.Хүрэлбаатар, С.Чинзориг;
Чөлөөтэй: М.Оюунчимэг.*

Нэг. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, референт А.Хонгорзул нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан үг хэлэв.

Ц.Цэрэнпунцаг: “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 09 минут үргэлжилж, 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр,

Лхагва гараг

Төрийн ордны “Үндсэн хууль” танхим

14 цаг 00 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Ц.Цэрэнпунцаг ирсэн байна, Дамбын Батлут гишүүн орон нутагт ажиллаж байна, Б.Батгөмөр гишүүн ирсэн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Ж.Ганбаатар гишүүн гадаадад томилолттой, Н.Ганибал гишүүн орон нутагт ажиллаж байна, Х.Ганхуяг гишүүн ирсэн, Ц.Даваасүрэн гишүүн гадаадад томилолттой, Т.Доржханд гишүүн гадаадад томилолттой, Б.Жавхлан гишүүн ирсэн, Д.Өнөрболор гишүүн ирсэн, М.Оюунчимэг гишүүн чөлөөтэй, Ч.Ундрэм гишүүн ирсэн, Ч.Хүрэлбаатар гишүүн гадаад томилолттой, О.Цогтгэрэл гишүүн ирсэн, С.Чинзориг гишүүн орон нутагт ажиллаж байна, Б.Энхбаяр гишүүн ирсэн, Т.Энхтүвшин гишүүн ирсэн.

Өнөөдрийн хуралдаанд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 сарын 13-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хороогоор хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Улсын Их Хурлын даргын 2024 оны 25 дугаар захирамжаар байгуулагдсан Газрын тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт, газрын зөвшөөрөл олголт, ашигт малтмалын нөөцийг ашигласны төлбөрийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төсөвт төлөх үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, санал дүгнэлт гаргах, хянан шалгах, түр хороо байгуулах бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн удирдамж батлах асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 25 дугаар захирамжаар байгуулагдсан хянан шалгах ажлын хэсгийн удирдамж батлах асуудлыг хэлэлцэж эхэлье.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд тараасан.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Ажлын хэсгийн удирдамж батлах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын даргын 2024 оны 25 дугаар захирамжийг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Газрын тухай болон Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, газрын зөвшөөрөл олголт, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төсөвт төлөх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж санал, дүгнэлт гаргах, хянан шалгах түр хороо байгуулах бэлтгэл хангах” үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо Ц.Цэрэнпунцагт даалгасугай гэсэн тогтоолын төсөл байна.

Та бүхэнд Ажлын хэсгийн удирдамжийн төслийг тараасан байгаа.

Гишүүд төсөлтэй холбогдуулан асуулт, санал байна уу? Нэрсээ өгнө үү. Б.Жавхлан гишүүн асуулт, саналаа хэлье.

Б.Жавхлан: Баярлалаа. Тэгээд энэ ажлуудаа хэдүүлээ хавартаа амжуулах хэрэгтэй. Энэ чухал байгаа.

Энэ дээр зүгээр би протоколд нэг ийм санал гэх юм уу, юу гэх юм. Нэг ийм өөрийнхөө байр суурийг хэлчихье гэж бодож байна.

Энэ АМНАТ дээр бид маш их шүүхдэж байгаа шүү. Мэдээлэл өгөхөд.

Сангийн яамны АМНАТ тооцож байгаа аргачлал буруу байна. Илүү аваад байна. Давхар аваад байна.

Одоо бүр хил нөхцөлөөр бид АМНАТ-аа тооцоод. Одоо жишээ нь нүүрс дээр **SXCoal**^[Shanxi Coking Coal Group] гэдэг

¹ Хятад болон олон улсын нүүрсний зах зээлийн мэдээ, дүн шинжилгээ, үнэ, статистик, тайлан.

биржийн үнийг авч шууд АМНАТ авдаг юм. АМНАТ тооцож авдаг юм.

Гэтэл нүүрсний компаниуд юу гэдэг вэ гэхээр бид гадагшаа экспортолж байгаа гэрээнийхээ үнээс АМНАТ төлнө гэдэг. Тэр нь бүр хамаагүй бага үнэ болчихоод байдаг байхгүй юу.

Тэгэхээр АМНАТ гэдэг маань өөрөө Үндсэн хуулийн 6.2-оор ард түмний баялгийг ашигласныхаа төлөө төлж байгаа төлбөр. Нөгөө талаас төр тэр ард түмний баялгийг тэдэнд ашиглуулснаараа ард түмний өмнөөс цуглуулж байгаа нэг хэлбэр нь татвар байгаа юм.

Тэгэхээр үүнийг бид аль болох гүйцэд авах ёстой. Ийм зарчим барьж ирсэн байгаа юм.

Тэгэхээр бид шүүх дээр яагаад дандаа дуудагддаг вэ гэхээр дандаа хувийн нөгөө нүүрс экспортлох аж ахуйн нэгжүүд эднийх ерөөсөө АМНАТ илүү аваад байна, буруу аваад байна, давхардуулж аваад байна, өндөр үнээс тооцож аваад байна гэсэн ийм өргөдлүүдээр дандаа шүүх дээр очдог юм.

Тэгэхдээ шүүх дээр ерөөсөө ганц ч ялагдаагүй. Дандаа ялаад яваад байгаа.

Тийм учраас Улсын Их Хурал гэдэг бол төрийн дээд байгууллага. Эндээс гарч байгаа ажлын хэсэг Засгийн газрын барьж байгаа байр суурь, энэ АМНАТ-ыг тооцож байгаа байр суурийг ер нь нэг байх ёстой болов уу гэж ингэж бодож байгаа юу? Нэг нь хуулийг нь гаргаж байна. Нөгөө нь хуулийг нь хэрэгжүүлэх гээд АМНАТ-аа тооцоод аваад явж байгаа учраас.

Тэгэхээр үүнийг ажлын хэсэг ажиллаж эхлэхээс өмнө ер нь протоколд үлдээчихье л гэж бодож байгаа юм.

Бид эндээс ерөөсөө огт огт ухарч болохгүй шүү л гэж хэлж байгаа юм. Тийм. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Б.Жавхлан гишүүн ажлын хэсэг, цаашдаа хянан шалгах түр хороо байгуулаад ажиллахад хамгийн түрүүнд энэ асуудлыг анхнаасаа бодолцож явах ёстой шүү гэдгийг тодорхой хэллээ.

Үүнийгээ сайхан протоколд тусгаад, ажлын хэсэг цаашид ажиллахад үүнийгээ бид анхаарч ажиллая. Ингэж бодож байна. Ингээд цөмөөрөө санал хураалтаа явуулъя.

Санал хураалт хураахын өмнө би бас товчхон мэдээлэл өгье.

Манай гишүүд сая чуулганы завсарлагаанаар тойргуудаар ажиллаад нэлээн зав чөлөөгүй ажиллаж байсан учраас Их Хурлын даргын захирамжаар ингээд ажлын хэсэг байгуулагдсан.

Энэ ажлын хэсэг “Хянан шалгах түр хороо байгуулах”, энэ ажлыг бэлтгэх, бэлтгэл ажил хийх ажлын хэсэг дэд ажлын хэсгээ гаргаад ажлын хэсгүүд ажиллаад шаардлагатай мэдээллийг бэлдсэн.

Хуралдаан 09 минут үргэлжилж, 14 цаг 09 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД

Ажлын дэд хэсэг ажиллаад бараг хоёр долоо хоног, гурав дахь долоо хоногтоо ажиллаж байгаа юм.

Тийм учраас ажил нэлээн цэгцрээд явж байгаа. Тэгээд ерөнхийдөө бидний энэ ажлын хэсгийн удирдамж ерөнхий тусгаж өгч байгаа. Цаашдаа ажлын хэсэг ажиллаад, ингээд хянан шалгах түр хороо ажиллах асуудлуудаа нарийвчилж явна, энэ цар хүрэн дотроо гэж бодож байна. Ингээд санал хураалтаа явуулж эхэлье.

Саналын томъёололыг Та бүхэндээ уншиж танилцуулъя.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 60.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг үүгээр дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаандаа идэвхтэй оролцож, энэ ажлын хажуугаар оролцсон гишүүддээ маш их баярлалаа. Баярлалаа.